



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

### Торгуулийн арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, “Гишүүнчлэлийн журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1.2, гишүүн компаниудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй 1 дүгээр хавсралтанд заасан нэр бүхий 8 компаниас тогтоосон хэмжээний торгуулийг нэхэмжлэн төлүүлсүгэй.
2. Энэхүү тушаал гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан торгуулийг төлж, гаргасан зөрчлийг арилгах, ногдуулсан торгуулийг дурдсан хугацаанд багтаан төлөөгүй тохиолдолд арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээ авахыг дээрх компаниудад тус тус анхааруулсугай.
3. Тушаалын 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компаниудад нэхэмжлэх хүргүүлэхийг Санхүү төлөвлөлтийн алба /Г.Цэвээндорж/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР



Гүйцэтгэх захирлын 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 17 тоот тушаалын хавсралт

**Торгууль төлүүлэх гишүүн компаниудын нэр**

№	Компанийн нэр	Торгуулийн хэмжээ /төг/
1	Абжя ХХК	100,000
2	Бага хээр ХХК	100,000
3	Говийн ноён нуруу ХХК	100,000
4	Догсон ХХК	100,000
5	Нэйшнл секюритис ХХК	100,000
6	Тавантолгой хишиг ХХК	100,000
7	Финанс линк групп ХХК	100,000
8	Эм ай би жи ХХК	100,000

-----oOo-----